

МОНГОЛ ХЭЛНИЙ “ХАР” ХЭМЭЭХ ҮГИЙН
САЛАА УТГЫН ОНЦЛОГ

М.Базаррагчаа
Ч.Бямбаханд
/МУИС/

Монгол хэлний “хар” хэмээх өнгө заасан тэмдгийн нэр нь бусад тэмдгийн нэрээс утга агуулгын хувьд өргөн дэлгэр бөгөөд нэлээд өвөрмөц онцлогтой юм. Жишээлбэл, Б.Ренчин гуай “хар хүн” гэх үгийн эртний утга нь эмэгтэй хүн, эр нөхрөө нэрлэдэг болохыг тэмдэглэж, монгол зарим аймгийн гэрлэх ёсны байдлыг гэрчлэх сонин нэр томьёо¹ юм гэжээ. Үүнчлэн монгол хэлний “хар” хэмээх үг бусад үгстэй холбогдон элдэв хэлц утга үүсгэдгийг дараах байдлаар ялгаж болмоор байна. “хар” гэсэн өнгө заасан тэмдгийн нэр нь өнгө өнгөтэйгээ хольцолдох, өнгө заасан үг өөр бусад үгтэй хольцолдох гэсэн эсрэг тэсрэг хоёр утгаар ялгарч байна. Тухайлбал,

I. Зэрэгцээ харьцаа бүхий үгийн санжсан буюу хэвшмэл хэлц холбоо үг
1.а.

хар { хөх
ногоон
бор
хүрэн
саарал
хээр
бараан
буурал
эрээн
халиун
халтар
тарлан
цоохор

гэх мэтээр хоршоо үг бүтээж өнгө хольцолдсон утга үүсгэх ба “бор хар, бараан хар” гэгчлэн тонгоргож болно. Жишээ нь:

-Хүрэн царайтай том гэгчийн нуруутай тангадын мэхийн ёсолж, дээшээ сууна уу гэж гарын алга өөд харуулан сандлын зүг заасанд хариу ёсолж тана шигтгэсэн сийлмэл түшлэгтэй *хар хүрэн* суман модон сандал дээр суужээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тогоо эмгэн, хүн болсоор ер сайд хүнийг үзээгүйн дээр, хүргэн охин хоёрын сандран тэвдсэнд сэтгэл зовниж, Сувдын хойноос дагалдан гарваас, машин,

¹ Б.Ринчен, “Монгол бичгийн хэлний зүй”, дөтгөөр дэвтэр, дэд, өгүүлбэр зүй, Уб, 1967, 58-р т.

сургуулийн том хашааны төв дундад хүрээд зогсож, жолоочийн хажууд сууж байсан, *хар ногоон* дээлтэй, итали гоёмсог бүрх малгайтай хүн угтсаар айсуу хэдэн хүнийг хараад инээмсэглэв. (Б.Р “Үүрийн туяа”)

-Наран шингэх үес хоньчин, ам муруйн ярвайж үхсэн, зүс царайн үзэшгүй муухай хөхрөн *харласан*, бадарчийн хүүр, хээр хэвтэж байсныг олж ихэд айжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Хоёр дахь тэмээ Доржийн анх удаа аянд явж байгаа дөрвөн настай цагаан тайлаг байв. Тэр амьтан эгээ л хүүхэд шиг үе мөчөө атируулан, бяцхан цагаан толгойгоо угжгар бөхөндөө тулган, хажуулдан хэвтэнэ. Цэвэрхэн бор туулай хамраас нь *хүрэн хар цус* гарснаас нь Хүрэл зүрх нь хагарч гэж мэдэв. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

1.6. “хар гурил, хар байван, хар талх, хар тугалга, хар хусам, хар бурам, хар тогоруу, хар сойр, хар будаа, хар зээргэнэ, хар гүйлс, хар галуу, хар хэрээ, хар балчиргана” гэх зэргээр “хар” хэмээх тэмдгийн нэр нь шууд утгаар угсран орж, хэвшмэл нийлмэл үг бүтээсэн нь ихэвчлэн нэр томьёо бүтээдэг ажээ.

Мөн хоршсон тэмдгийн нэр нь тус тус бие даасан юмыг заасан байвал, өнгө хольцолдох гэсэн утгагүй байдаг.

Жишээ нь: *Шар хар лам*, түшмэдийн дунд ч амбаны гар хөл болсон хүн бий юм гэнэ билээ. (Б.Р “Үүрийн туяа”) гэхэд “шар хар” нь “шар лам, хар түшмэл” (феодал) гэсэн салангид утгатай тэмдгийн нэр болно. Мөн нэг юмын доторх хоёр өөр өнгө зэрэгцэн орсон нь буй. Жишээ нь: хөх торгон даалин дээлтэй, хар цагаан хурган чихтэй, хөх цэмбэн малгайтай, гялалзсан булигаар шинэ гуталтай цэрэг их л гоё сайхан үзэгдэж, хүн шүү хувцас өмссөндөө урамшингаа жагсаал сургуулиа тэр өглөө бузгай хийжээ. (Б.Р “Үүрийн туяа”), хар араа (малын ус өвс, эрдэс тэжээлд фтор илүүдэж, араа үүдэн шүд, хар бор өнгийн толботой болж харлах, малын эрдэс солилцооны өвчин) (Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь-д (2008) хар арьстан (африк тивд амьдардаг хүмүүс), хар байван (нэгэн зүйлийн хужир), хар гурил (хөх тарианы гулр), хар гэр (ядуу бор гэр), хар дэл (дэл гэдэг ургамлын үрийн харыг хэлнэ), хар талх (хөх тарианы гурилаар хийсэн талх), хар тос (олсны үрийг шахаж авсан тос), хар тугалга (хорголж, зөөлөн бөгөөд хүнд хөхөвтөр өнгийн төмөрлөг), хар хас (бараан хар өнгөтэй нэгэн зүйлийн хас чулуу), хар хусам (түлэгдэж харласан хусам), хар хөрс (тариалан тарихад тохиромжтой үржил шим бүхий бор хөрс), хар шороо (хар хөрсний шороо), хар нүд (хүний хүүхэн хараа цэцгий), хар саарь (хар сарьс), хар сарьс (битүү туурайтны хондлойн арьсаар элдэж хийсэн илэг), хар цагаан (эсрэг тэсрэг хоёр өнгө), хар амар (амар загастай адил бөгөөд хөх гэрэлтэй нэг зүйл загас, мах сайнгүй, зохимж муутай цөсөөр нь нүдний өвчин засна), хар галуу (бие хар, хошуу матаастай хэрээнээс томхон, нэгэн зүйл шувуу), хар голио (үнсэн өнгөтэй болоод харавтар, жигүүргүй хэвэл том түрс орхихгүй хэвлээсээ хорхой гаргадаг голой), хар гургуул (хэлбэр гургуултай адил бөгөөд бараан өнгөтэй шувуу), хар дэлэнч (нэг зүйлийн жижигхэн ялаа, төрөл зүйл олон), хар нүдэн (начин шувууны адил бөгөөд бяцхан нэгэн зүйл махчин шувуу), хар өрөв (бие цагаан, омруу чандар харавтар өнгө) хар сойр (сойр шувууны нэг зүйл), хар тогоруу (тогоруу шувууны нэг зүйл), хар үнэг (цагаан сортой, хар үстэй үнэг), хар хайга (өргөн хавтгай хэлбэртэй нэгэн зүйл загас), хар хөхөө (толгой нуруу бараавтархан, сүүлэндээ цагаан чандартай, охор хөлтэй тавгийн өмнө хойноо хошоод хуруутай нэг зүйл шувуу), хар хул (барс шиг бидэртэй, таван хумстай, өргөн цагаан нүүртэй нэгэн зүйл араатан амьтан, гавшгай бөгөөд догшин), хар хулан (янз үнэгтэй адил болоод хар, үхрийн толгой шиг толгойтой, ганц эвэртэй, жил удвал

хайрс ургадаг, сүрхий махчин араатан амьтан), хар агар (цайвар хөхөвтөр өнгөтэй, сайхан үнэртэй мод), хар балчиргана (агширганы өөр нэр), хар будаа (хар хальстай жижиг шар будаа, зэрлэг таримал хоёр зүйл байдаг), хар бурам (чихрийн ургамлын чихрийг боловсруулан аваад, үлдсэн шаарыг хорхоглон өтгөрүүлж хийсэн нэгэн зүйл чихэрлэг, идээ, зэрлэг ургасан зэгс, хулсны түрүүнээс гарах нь бий), хар гүйлс (модноос ургадаг түүхий үедээ ногоон, боловсормогц шаравтар өнгөтэй болно. Утаагаар утвал харавтар өнгөтэй болно. Маш исгэлэн амттай нэг зүйл жимс), хар даль (далийн төрлийн ургамал, гол төлөв ягаан цэцэгтэй анхилам үнэртэй шөвгөр уртлаг навчтай мөнх ногоон жижиг мод), хар зээргэнэ (морин зээргэнийн өөр нэр, навчгүй нэгэн зүйл сөөг), хар маалинга (халтсны өнгө хар нэг зүйл маалинга), хар майлс (илжгэн чих, хурмагийн мод), хар мөөг (доторх салбан нь хатахдаа хар болдог дэлбэгэр мөөг), хар нэрс (нэгэн зүйл жимсгэнэ), хар хамаг, хар хамхаг, хармаг (элсэрхэг улингар газарт ургах бутархаг өвс), хар хус (хөхөвтөр өнгийн арзгар үйс, зузаан навч нягт ширхэгтэй тураг мод), хар хэрээ (нэгэн зүйлийн бараан шувуу, нэгэн зүйл махчин шувуу, урт нь 64-66 см, хүйтэн сэрүүн газар түгээмэл байдаг, ямагт хоёроороо явна, хавар эрт модны оройд өндөглөнө), хар чийр (гондийн нэг зүйл), хар шаваг (шавгийн төрлийн нэг зүйл бут), хар шарилж (шарилжны төрлийн нэг зүйл), хар нүх (хэдэн сая нарны масс нэг цэгт хуримтлагдах үед бий болдог физикийн гайхамшигтай огторгуйн биет), хар цай (нэгэн зүйл цай, шахмал задгай хоёр зүйл бий), хар нүд (хүний хүүхэн хараа цэцгий) гэх мэт.

-Аян хийсэн олон жуулчин, *Хар балгасанд* бууж, сүрлэг байдалт эртний тэр эвдэрхий балгасны орчин тойрон хүн амьтангүй, эзгүй газар, шингэх нарны гэрэлд адуу тэмээ, орос монгол хүн бужигнан, аравдугаар зуунаас нааш тийм их олон хүний хөлтэй хөдөлгөөнийг үзээгүй, Уйгарын эртний тэр хотын эвдэрхий хэрэм балгасанд хүн амьтны дуун цуурайтаж, адуу унгалдах, тэмээ буйлах, орос монгол үг хэлэлцэх чимээ сонсогджээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тэмээний доогуур *хар хар юмс* бүртэгнэн гүйхийг үзлээ. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Гадаа үүр цайсан болов уу гэлтэй байвч нэвсэрсэн *хар уул* тэнгэрийг битүү бүрхэн шөнө мэт байгаа бөгөөд хашаа дүүрэн гамин байгаа нь л тодхон үзэгдэнэ. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Хэл буруутны гарт иймэрхүү явж байхад бас эндхийн лус савдаг мөн уурлан хилэгнэх мэт том ширхэгт цасыг зай завсаргүй хаялж эхэлнэ. Одоо бол халх оронд тэсгим жаварт дүн өвлийн цаг сан. Гэтэл энд тийм биш, орсон цас газарт буухтайгаа зэрэг хайлан нунтаг *хар шороог* лагалдуулна. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Өөх тос, элгэн цагаан идээ, болсон түүхий будаа, гурил бөгөөд түүнээ гагцхүү өвөр лүүгээ чихэн хийх тул өвөр нь маш том болоод бөөн *хар хир буртаг* явна. (Д.Нам “Цаг төрийн үймээн”)

-Аа тэг хүүхээ. Энд чинь ёстой хүний *хар нүднээс бусад нь байдаг газар* гэж санаа сэтгэл нь сэргэх болов уу гэхдээ уриалгахнаар хэлэн, мориныхоо амыг татлаа. (Д.Нам “Цаг төрийн үймээн”)

II. Энэ тэмдгийн нэр нь шилжсэн салаа утгаар орж буй өвөрмөц хэлц

2.а. Дан ганц зөвхөн буюу цэвэр дагнасан гэсэн утга илтгэнэ. Тухайлбал, хар хүн (дагнасан нөхөр), хар чийг (зөвхөн шөнө, үдэшдээ буух чийг), хар тавхай (зөвхөн тавхайн ёроол), хар амиа бодох (зөвхөн өөрийгөө бодох), хар хамраараа таслуулах (яг урдуураа таслуулах), хар хөлс асгарах (дан хөлс гоожих), хар ажил

(дан биеийн хөдөлмөр), хар сээр (сээрийн гол нэг нугалам яс), хар айраг (дан цагаан гүүний сүүгээр исгэсэн айраг) Жишээ нь:

-Чичрэг өвчин тусаж, шонтгор богино хамартай, халзан их духтай, чавганц царайтай тэр ноёны улцгар нүүр нь *хар хөлс* чихарч, хэвтэж байсан билээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-*Хар хүн* чинь миний хонины махыг төлж өгөг дуулав уу? гэж хашгиртал... (Б.Р “Үүрийн туяа”)

-Хоёрдугаар удаад нь дээрхийн гэгээнтэн, *хар үүрээр* гэнэт бушуу цай аваад ир гэж зарлиг болдог байжээ. Цай сая л чанаж арай сүлж гүйцээгүй байлаа. (Б.Р “Үүрийн туяа”)

-Альд нь байна уу? Морь эмээллэ! гээд Богд гарын дор тохиолдсон нэг ламыг дагуулж, шар хүүхэнтэй хамт Гандан өөд *хар хурдаар* таварган давхижээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тэр айлын хүүхэд, эмэгтэйчүүд, чавганц нар Шамба сэлтийн хойноос хараал тавьж үнс шороо цацах нь үнс шороо цацаж, хар ус цацах нь хар ус цацав. (Б.Р “Үүрийн туяа”)

-Өвгөн Жан, хүн бүр, өөрийн эрхэлсэн урлах дархлах, юм бүтээх ажлыг хийгээд дэлхийд юу ч болж байсан ер бусдын хэрэгт хөндлөнгөөс эс оролцвол, сая хүн бүр аяга будаатайгаа болж чадна гэж *хар ухаанаараа* боддог байжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-*Муу хар гуйлгачин*, мориноос буу! (Б.Р “Үүрийн туяа”)

-*Хөвчийн хар дархан* гэдэг алдрыг чинь дээрээс сонсож, найман хигээстэй хүрдэн тамгыг чинь хэд хэд үзсэн. Энэ чиний гарын ур биш биз? гэж хутгаа үзүүлбэл, хөвчийн хар дархан тэр хутгыг сэтгэл хөдлөн үзээд... (Б.Р “Үүрийн туяа”)

-Огторгуй ихэд уйлахад хүрвэл, ганц миний *хар толгой дээр* уйлах юм биш, дая олны толгой дээр уйлах юм байлгүй дээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тасдаад хаяна даа эмгээ! Олны бухимдаад үймээд ирэхэд нэг самбаанд нь тасдаад хаячихна гэж далан нөхөөс болсон уранхай дээлтэй, нэг хүдэр *хар хүн* дуугарав. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тэгээд хониноороо ганцаар үлдээд, хөхрөн харагдагч тэнгэрийн хаяаны зүг холдож яваа аянчны хойноос удтал харж зогсохдоо, манжийн төр эцэс болох цаг ойртож байгаа юм гэж *хар багаасаа* сонссон дам үгийг санаж, Монгол нийгмээр эрх чөлөөтэй, амар сайхнаар жаргах цаг ирэх юм гэж хэлэлцдэгийг бодоод, Батбаяр өвгөө, миний багад ярихдаа, юм бүхэнд хэмжээ байдаг юм даа. (Б.Р “Үүрийн туяа”)

-“Цагаан сар ба *хар нулимс*” (Д.Нацагдорж)

-Хангай говийн хооронд халхын уудам нутаг

Хар бага наснаас хөндлөн гулд давхисан газар (Д.Нацагдорж)

-Хуриманд ирж согтоод Буянхишиг Да лам, “Хувилгаан сүнс” гэж өөрийгөө дөвийлгөн агсганадгийг санагдуулж, Цэрэнлхамын *хархуутэй* тэврэлдэн суугааг хараад “уур нь бадарч” Лодон “байшингийн хаалгыг хэмх цохин орж хэрүүл шуугиан гаргаж байна. Буянхишиг Да лам Ванлийгийн өөр хүнтэй суух “мөрий нь өдрийг сонсоод” дугана сүмдээ муужран унаж улмаар хуриманд нь очихоор явахдаа... (Д.Нацагдорж)

-Хашааны булан тохойгоор яваа хүмүүсийн хувцасны өнгө ялгаран *лам хар нь* танигдахуйц тэмээг хэвтүүлэв. (Д.Намдаг. “Цаг төрийн үймээн”)

-Гэрийн хаалга зөөлнөөр онгойж нэг хүн дуу чимээ гаргахгүйг хичээнгүйлэн орж ирсэн нь арван тав, зургаа орчим настай, нарийхан биетэй гурдгархан *хархуу* байлаа. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Залуудай, эмэг эхийн хамт, Поодойн цөмөрсөн өрхийн дэргэд очиж, доошоо эмээн харваас, хирис, өрхийн дээврийг махаараа цөм дарж ойчихдоо, нарийвтар сургааг унин дээр **хар модны** долон холтос дэвсэж, дээрээс нь ширэг жигдлэн өрж хийсэн дээврийг нь цөм дарж ойчихдоо, өрхийн тооно тулсан дөрвөн баганын нэг нь цав гарсан газраа цуурч, шор мэт хурц үзүүртэй болсон нь, тэр нүсэр том амьтны гэдсийг нь нэвт хатгаад, бөөрөн тушаа нь цус бултайн цухуйжээ. (Б.Р. “Заан залуудай”)

-Санамсаргүй сахлаа илэхэд хурууны нь үзүүрт хүйтэн, нойтон юм баригдав. Энэ нь тун саяхан асгаруулсан нулимс хацраа даган урссаных байжээ. Балданцэрэн тийнхүү уйлснаа санахтайгаа зэрэг, би сахал самбайгаа хүртэл ургуулсан нэг ёсны *төрийн хар хүн* байж, ухаан жолоогүй уйлах нь юу вэ? гэж зүрхээ чангалан цааш явлаа.

-өөрийнхөө хэргийг дэвэн дэлхийд мэдэгдэх гэсэн юм шиг *хар тэнхээгээрээ* хашгичин ярив. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Гэтэл чамаас эхлэн *хар амиа бодох* нь юу вэ? (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Гэвч Балданцэрэн нэгэнт тэндээс *хар багаасаа* тасарч малын захаас холджээ. (Д.Нам “Цаг төрийн үймээн”)

-Үүнийг би чамд *хар хорын сэтгэлээс* хэлж байгаа биш, эмэгтэй бидний хувь заяа нэгэн адил дорой болоод, гаслан зовлонгийн дунд хүлээстэй байдгийн хувьд хэлж байна. (Д.Нам. Цаг төрийн үймээн)

2.6. Бүхэлдээ муу муухай ба муушаасан баймж гэсэн утга: хар толбо, хар амтай, хар дотортой, хар үйл, хар мөртэй, хар санах, хар буух, хар дарах, хар элэгтэй (муу санаатай), хар ихтэй, арван хар нүгэл, хар ихтэй (маш сэрдэмтгий)

-Тийм байлгүй, сүнсээ алдсан *хар ноход!* Удахгүй тэр чандруунуудтайгаа цуг үнсэн чандруу болон тонилохоо мэдэж байна уу? (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

- Энэ юун сав бэ? Шорон уу? Биш, зорь! Тэгэхдээ ногооных биш, хүнийх ёстой хүн нэрэн дээр нь амьд хүүр болгодог *хар тамын зорь*. (Д.Нам. “Цаг төрийн үймээн”)

-Хаалга нээ, хөгшин *хар илжиг*. Бид цэргийн улс, танай данжаадтай уулзана гэхэд нь, (Б.Р “Үүрийн туяа”)

-...хүний морь хөлслөөд хөлсийг нь өгөхгүй, задарсан *хар тархи* вэ, хө чи? Би чамайг гар хоосонгүй эрхбиш явсан хүн гэж яс зуух байх гэж бодсон чинь биш болжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Чиний зөөлөн сайхан сэтгэл чинь, миний нүдийг бөглөсөн *арван хар нүглийн*

саравчийг сөхөж өглөө. (Б.Р “Үүрийн туяа”)

-Хүрээний амбас, тэр мэдээг олж сонсоод олныг өдөөн хатгаж самуун өдүүлэгсдийг барьж чандлан шийдтүгэй гэж олон хошуугаар тусгайлан зарлаж, тэр ёсоор олон хүнийг хар гэрт хийсэн гэнэ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Аа, муу хар гэмин, чи энд хоргодож байдаг юм бий? Мөд чи үхсэн хар илжиг болно доо. (Б.Р “Үүрийн туяа”)

-Хар үгэнд наймаа хятад хоёр гэж нэг ухагдахуун байжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Нүүртээ тойрсон мянган *хар нүдтэй*... (Б.Р “Үүрийн туяа”)

-Миний хэсч үзсэн газар их боловч, би өнчин өрөөсөн *хар яст*, харц ард, Далай ван болбол, цагаан яст хүн болоод, биеэ номтой ч гэсэн ноён, номгүй ч гэсэн харц нарыг захирах ноён гэж үздэгийн нэгэн билээ. Ван, манжийн үед ч эрхтэй, ямбатай, дураараа байжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

2.в. Эгэл энгийн гэсэн утга: хар болох (төрийн шашны биш болох), хар иргэн (эгэл ард), хар тэргүүт (энгийн иргэн, хүн төрөлхтөн), хар гэртээ хаан, бор гэртээ богд, хар яриа, хар үг

-Гээгний тав тавьсан саяхан *хар* болсон байдалтай нэгэн цоохор цэрэг богц дотроос хонины болгосон хоёр толгой гаргаж Ширчингийн зүг аньсхийж, (Б.Р “Үүрийн туяа”)

-Мал сайхан зуншиж байна гэж хариулаад, салхины нь дороос зайлж, хоорондуураа салхи цохихоор тааруулан морио зогсоосон учир нь, Дүйнхараас яах аргагүй өмхий шиврийн үнэр ханхалж, ой гутмаар муухай бөгөөд, харвал *ажлын хар гутлын зулаг шивэрт* нь нойтон үзэгджээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Муу хар овоохойдоо галайхаан эхийг тахиж, умар зүгийн *Хар Тогмагын* газраас тэмээний хишиг хүртэж, Төмөр уулын газраас хурдан буу хурц ирт хутга мэсийн хишиг хүртжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Чингээд хүрээлэн буусан хуарангийн утаа болсон хуучин *хар майхнуудын* тэнд хүрээд, тэр цэрэг Ширчинг нэг майханд оруулаад, Дүйнхартай хоёулан Жамсранжав бэйсэд айлтгах гэж, олон майхны төв дунд, үүдэндээ туг зоолттой улаан халзан том гэр лүү оржээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Урьд өмнө дуулдаагүй тэр өгөөмөр болсныг жасын мал харж байсан ядуу зарц нарын хүн бүр агшин зуур сонсоцгоож, гэнэт тийм болсныг ноорхой *хар гэртээ* гайхан хэлэлцжээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-Тэр завсар, сор залахыг харах гэж цугласан олон *харчуул*, ам амандаа ярих нь ярьж арилжаа наймаа хэлэлцэх нь наймаа хэлэлцэж яргачин, панзчин, мал худалдахаар ирсэн ардуудтай ханцуй дотроо хуруу атган үнэ хэлэлцэж гуйланчин, төлөгчин, хятад хайрцгийн наймаа, дамнуурчин, газар дороос гарсан юм шиг олны дотор бий болж боов чихэр, маахуур, маатан худалдаж эхлэв. (Б.Р “Үүрийн туяа”)

3.а. төрөл биш, харь, онцгойрох ялгарах гэсэн утга: харь элэгтэн (харь хүмүүс),

хар нүдэн хийх (айрагт архи холих), хар нүд хага татах, хар нүд хуулах, хар цагааныг ялгах, хар нүдэн хонь, хар цагааны газар, жич: Норжин нарын тольд хар хэмээх үг нь хамаг, бүгд, буй, бүхий, (хар хурдаараа давхих, хар хүч) гэсэн утгыг тэмдэглэжээ.² бичиг хар (бичиг бусад зүйл), мал хар, хүн хар, данс хар, морь хар гэхчлэн “бас бус, юм, бүгд” гэсэн утга, илтгэж, бүхэлжсэн хэлц холбоо үг бүтээнэ. Тухайн юмыг бүхэлд нь “харлуулан” муухай болгох гэсэн утга нь “дагнасан буюу холих найрах утгагүй “хар хүн, хар цас, хар хөлс, хар тамир” зэрэг холбоо үгээс салаалж, өгүүлэгч этгээдийн муушаасан баймж утга нэмсэн байдгаараа ялгарна. Жишээ нь: хар гамин, хар нохой гэвэл “хар” хэмээх үг нь “дан, дагнах” гэсэн утга буй боловч юмыг жигшин муушаасан баймж утга нэвт шингэсэн байгааг ажиглана уу?

-Хожим хойчийн нэгэн цагт манж нарын хуучин данс хараа агуулах газраас эрхэм өв тэгш эх бичиг тарах болзошгүй. (Б.Р “Үүрийн туяа”)

-Би арай гэж нэг гүзээ тос, *хар баагаар* өгч явуулсан. Юм авахгүй гээд халгааж өгсөнгүй. (Б.Р “Үүрийн туяа”)

-Энэ хэргийн үнэн худал, *хар цагааныг* яаж мэдэх билээ. (Б.Р “Үүрийн туяа”)

-*Хар өглөө* арайхийж, *хоёр хар нүдээ* хага татаад хараал хийж гардаг тань яасан жигтэй юм бэ? (Б.Р “Үүрийн туяа”)

-*Харцагааня*с холилдож, харцноёд хутгалдаж болохгүй гэж эвэртэн сүүлтэнгүүдийн гэр өргөө барих газар нь бас анги газар бий гэж тэр цагдаагийн ярихад Батбаяр, тоглож байгаагий нь бүү мэд, үнэхээр асууж байгаагий нь бүү мэд. (Б.Р “Үүрийн туяа”)

4.а. Нууц далд (хамгаалах, нууцлах) гэх мэт утгыг илтгэдэг гэж болно. Жишээ нь: хар хайрцагны бодлого гэх нийлмэл хэлц нь хар авах, хар дотор, хар арилжаа, хар санах зэрэг үгсийн хардах сэрдэх утгаас эхтэй гэж болно. (хар арилжаа) гэх мэт. Жишээ нь: Цэрэн,- Би мөнгөндөө **хар буугаад** ч уйлж байгаа юм биш. (Б.Р)

-Гэвч манж нар, маш хартай улсаа, Жамгон Римбуучийг дайчин гүрний нутгаас гадагшаа гарч болохгүй гэж хориод, бараа болох амбан сайд, дэргэд нь томилж, наагуураа их ламыг хүндэтгэн ёсолж байгаа юм шиг...(Б.Р)

I ангилалын хувьд академич Б.Ринчен гуай “Хоршоо үгийн аймгийг ангилан үздэгийн шувтарганд бас элдэв хоршоо үг гэж ангилах нэг зүйл бий. Түүнээ багтах хоршоо үгийн байдал нь монгол хэлний сэтгэхүйн үүднээс нягтлахад дээрх хуваарьт орууламгүй бөгөөд монгол ардын утга соёл, эдийн боловсролын түүхнээс тайлбарлах зүйл болно.

“Хүн хар, данс хар, бичиг хар” гэх мэт хоршоо үгнээ хоёрдугаар хоршиц үг нь “хар” гэсэн өнгийн нэр үг бөгөөд “хар” гэсэн үгсийн утга нь нэг зүйл өнгөөс гадна, монгол хэлнээ хольцоогүй дан нэгэн зүйл гэсэн утга санаатай үг ажээ. “хүн хар” гэхдээ дан хүний зүйл, дагалдсан мал сүрэг зэргийг дурдахгүй, хүний нь голлосон санаа болгож “хар” гэдэг хоршоо үг зүүсэн учрыг өгүүлэлтэй.³ гэж тайлбарласан байна.

II ангилал нь “морь хар, данс хар” гэх мэт зэрэгцсэн хоршоо үгнээ морь

² Ц.Норжин нар, Монгол хэлний толь, Чуулалт хаалга, 1999, 1238-р т.

³ Б.Ринчен, “Монгол бичгийн хэлний зүй”, дөтгөөр дэвтэр, дэд, өгүүлбэр зүй, Уб, 1967, 59-р тал

данс зэрэгтэй холбоо бүхий зүйлийг хамруулах утга илтгэх нь “бүхэл хэсэг” гэсэн утгын “хэсэг бусад” гэсэн утга бүхий “хар” хэмээх тэмдгийн нэртэй холбогдоно. “хольцгүй дан, цэвэр, зөвхөн ганц, дагнасан” гэсэн гол утгаас дээрх 4-5 салаа утгын дундаж хоёрдмол шинжтэй үгс бас тохиолдоно. Жнь:

хар ус	а.дан ус б.архи (муушаасан утга)
хар гэр	а. зүдэг ядуу б. хорих гэр (шорон)
хараар наадах	а. шатрын хараар эхэлж наадах б. хар хор, мөрий атаагаар наадах
хар бор	а. хар өнгөнд цайвар өнгө орох б. эгэл боргил, хатуу, хүтүү
хар үйл	а. муу үйл б. бүдүүн хадуун зүйл,
хар толгой	а.цайраагүй үс бүхий б.зөвхөн амиа бодох
хар элэгтэй	а.муу санаатай б. харь удам угсаатан

Үүнчлэн “хар дэлэн” гэвэл а. муу муухай өвчин б. зөвхөн дэлэн нь хавдах өвчин гэж хоёрдмол утга мэр сэр дайралдаж байна. “Хэрээ хэрээнийхээ харыг гайхна” гэвэл а. хар өнгө нь ижил, б. нэг нь нөгөөгөөсөө ялгарах гэсэн санаа, тухайлбал, “Чинийх долоо, минийх долоохон” гэсэн санаа илтгэнэ. “хар” хэмээх өнгө заасан тэмдэг нэрийн салаа утгат холбоо үгсийг дээрх ангиллын дагуу хэрхэн орсныг үзүүлбэл, дараах байдалтай болно.

Г.И.Рамстедт⁴ хар алба-(татвар, албан ажил), хар гуяа (хөх гуяа), хар яс, хар өдмөг (хар талх), хар аюу (хар баавгай), хар газар, хар буурь, хар гөрөөс, хар сүлд, хар хулд, хар хул, хар хөө, хар хэдмэн, хар хэл, хар хөлс, хар хүн, хар мах, хар мод, хар мөрөн, хар нүүр, хар өдөр, хар шашин, хар сээр, хар таваг, хар тамхи хар толгойтой, хараас айдаггүй, харанхуйгаас цочдоггүй;

О. Ковалевский⁵ цаг sig- харанхуй, бүрэнхий, хар үйл, хар улс (энгийн), хар үг (ярианы үг), хар үхэр, хар нүд, хар нүгэл, хар халзан галуу, хар хус (чёрная береза), цага qula (барс), харын барилга (ургамлын нэр) хар бичиг (черновое письмо), хар сар (новолуние), хар сэтгэл, хар сээр, хар шажин (ислам), хар зүг (чөтгөр шуламс, сарын сүүлч үе) хар гэр (гал зуух), хар хятад (хар Кидан), хар хүснэгт там (гал там); гэсэн бол “Халимаг –Орос толь бичиг”-т;

- 1.1 хар харанхуй а.хар газар б. цасгүй газар
2. цэвэр, хольцгүй (хар мах, хар цай, хар ус, хар архи)
3. энгийн а. хар хүн б. төрийн хар хүн, хар яриа
4. хүнд (хар хөдөлмөр, хар хүч)
5. хорлонтой (хар санаат, хар хов, хар хэрэг), алдаатай, өөдгүй
6. хамгийн хүчтэй (хар хүйтэн хар салхи)
- 2.1 зөвхөн, ганц, онцгой, а. хар амиа харах б.хар өглөөгүүр
- 3.1 хараар наадах (шатар тоглохдоо хараар эхэлж нүүх)

⁴ G.J.Ramstedt. Kalmükisches Wörterbuch, Helsinki, 1935, p.168

⁵ О.Ковалевский, Монголо-Французский словарь, Т II, Казань, 1849 стр.823-826

2. муу үйл (хар санах, чүдэнзний хусах хар, нүдний хар цэцгий), хар ям, хар шажин, хар цагааныг ялгах, хар боргүй, хар сэр, хар даг, хар газарт ор-, хар хувцас, хар усан дээр өрөм тогтох, хар хүн (энгийн чөлөөтэй тайван амар) хар байх (энгийн байх);⁶

“Буриад-Орос толь бичиг”-т;

1.1 хар, хар шир, хар өнгө, хар нэрс, хар зандан, хар азарга, хар үнэг, хар гөрөөс, хар баавгай, хар нохой, хар шөнө, хар нүх, хар зүс, хар азарга, хар царай, хар тамхи, хар газар (цасгүй),

2.цэвэр хольцгүй; хар мах, хар цай, хар шөл, хар усаар хооллох, мөнхийн хар ус, хар архи

3. энгийн: хар хүн, хар зөн, хар хэл хар яриа

4. энгийн биеийн: хар хөдөлмөр (хар ажил, хар хүч)

5. хар барга хүн (мунхаг бүдүүлэг хүн), хар худал, хар дотортой, хав хар, хар санаа, хар гай, хар хэрэг

6. хамгийн хүчтэй, хар хүйтэн, хар салхи, хар бороо, хар багаасаа

7. жинхэнэ өөрийн: хар мөрөө хараад явах, хар тархиндаа гомдох, хар зөөр хар зоргондоо

2.1 зөвхөн онцлог: хар амиа харах, хар бие хүн, (ганцаар хүн)

2. маш нэн: хар эрт, хар түмэн (хар мянган)

3.1 хар: хараар хувцаслах, хараар наадах,

2. муу санах: хар хийх, хар санах, хар буух, хар бараг, хумсны хар, нүдний хар, хар шар (шар хүрэн)⁷ гэх мэтээр “хар” хэмээх үгийн утгыг дээрх байдлаар ангилан тайлбарласан байна.

Хэл шинжлэлд үгийн салаа утга, ижил үг хоёрын хооронд эрс зааг тавьж болохгүй хэмээн эрдэмтэд үздэг. Учир нь, үгийн утга салаалах нь харьцангуй хөдлөнг шинжтэй юм. Өөрөөр хэлбэл, тухайн үг хэлэхийн цуваанд ямагт шинэ утга бүтээх боломжтой байдаг. Эдгээр нь тухайн үгийн салаа утгыг бий болгож улмаар тэрхүү утга нь анхдагч үүр утгаасаа аажмаар холдон алсарсаар өөр зүйлийг тэмдэглэхэд хүрдэг. Энэ нь ижил үг болдог. Жишээлбэл, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь (2008)-д

хар I цагааны эсрэг утга, хөө нүүрс зэргийн өнгө (хар хяруу, хар сүлд, хар гурил)

хар II хардах сэрдэх байдал (хар авах, хар буух, хар дарах)

хар III бичиг хар (бичиг хэрэг болон бусад зүйл)

хар IV хар сээр (хүзүү сээрийн завсар дахь гаднаас түгдийж үзэгдэх нэг нугалам яс) гэснийг үзвэл “хар сээр” гэсэн үгнээ хар чийг, хар шөл, хар хяруу, хар борви, хар яриа, хар ажил гэсэн холбоо үгнээ орсон “дан ганц, цэвэр, нарийн” гэсэн утга хадгалагдан байна. Иймд “хар сээр” гэсэн холбоо үг нь тус тольд дурдсан I бүлэгт утгаараа багтаж болом санагдана. Ф.де Лессинг⁸, Я.Цэвэл⁹, Норжин¹⁰ нар энэ холбоо үгийг I бүлэг үгсэд багтаасан байна. Ийнхүү үгийн салаа утга¹¹ уу, эсвэл бие даасан ижил үг үү? гэдгийг ялгахад энэ мэт зөрөө гардаг байна.

Мэдэгдэхүүн хэлэгдэхүүний үүднээс, хэлний нэг гаргалгад нэг агуулга байх

⁶ Калмыцко-русский словарь. Под редакцией Б.Д.Муниева, М., 1977

⁷ Бурятско-русский словарь, Составил К.М.Черемисов. М., 1973, стр. 547-548

⁸ F.de.Lessing Mongolian-English dictionary. Bloomington,1982, p.931

⁹ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Уб.1966, 661-р т. 2013, 907-р т.

¹⁰ Ц.Норжин нар. Монгол хэлний толь, Чуулалт хаалга,1999, 1244-р т.

¹¹ Polysemy (*/pəˈlɪsɪmi/* or */ˈpɒlɪsɪmi/*,^{[1][2]} from *Greek*: πολυ-, *poly-*, "many" and σῆμα, *sēma*, "sign")

ёстой боловч, хэлний агуулга, гаргалга хоёр нь мэдэхүүн хэлэхүүний хувьд зөрөөтэй болдог. Үүнд,

ижил утга	салаа утга			
I. цага- цагааны эсрэг өнгө	А.	I.	дан ганц, зөвхөн, цэвэр, дагнасан	(хар хүн, хар тавхай, хар хамраараа таслуулах, хар сээр)
II. цаг- хар хар хийх		II.	эгэл энгийн	(хар болох, хар иргэн, хар тэргүүт, хар аяндаа, хар байх)
III. цаг-а харах	Б.	III.	бүхэлдээ муу муухай	(хар, толбо, хар элэгтэй, хар амтай, хар буух, хар мөртэй)
		IV.	онцгойрох ялгарах	(хар цагааны газар, бичиг хар, хүн хар, хар нүд хуу татах)
		V.	нууцлан далдлах	(хар хайрцгийн бодлого), хар арилжаа (нууц худалдаа), хар хор (далдуур хор хүргэх үг)
хэлний гаргалга	↔		хэлний агуулга	

Энэхүү ангилалыг жишээгээр баяжуулан тайлбарлавал,

Салаа утга			
A.	I.	хар амтай (дандаа муу юм ярьж явдаг) хар мөртэй (муу үйлстэй, бусдад дандаа гай болж явдаг) хар данс (муу зүйл бичиж тэмдэглэх данс) хар хэл амтай (ямагт муу муухай, сэжиг хүрмээр үгтэй, зүхэлч) хар зураг (хар цагаанаар ялгасан фото зураг) хар зураг (ерөнхий зураг гаргах) хар шоргоолж шиг (тоймгүй олон, маш олон) хар газар (цасгүй газар) хар сувай (ерөөс хээл авдаггүй эм мал) хар сүлд (монголын нэгдсэн тулгар төр байгуулагдсан үеэс эхлэн хэрэглэж ирсэн дайсныг айлгах догшин зүс бүхий хар өнгийн хялгасаар хийсэн эртний монгол цэргийн туг) хар лам (христийн шашны лам) хар ус (архи) хар цай (сүлээгүй цай) хар тавхай (тавхайн ёроол) хар хувцастан (улсын аюулгүй байдалд онц ноцтой хор учруулах гэмт халдлага, гэмт хэрэгтний	хар хөлс нь асгарах (ажил явдалд түүртэн ихэд хөлрөх, ихэд айж сандрах) хар бороон дундуур (яг бороо орж байхад ийм их бороон дундуур хэмээн түвэгшээх нь) хар өглөөгүүр (ийм эрт, өглөө эрт, яршиг удах) хар шуурганаар (очиж очиж шуургатай үеэр түвэг удах) хар бага нас (нялх бага нас) хар бага наснаас (балчир бага наснаасаа) хар үүрээр (маш эрт) хар хүн (эр эм бологчдийн эрийг нэрлэсэн нь) төрийн хар хүн (төрийн албан хаагч) хар ухаан (төрөлх ухаан, ажил амьдралаас олж авсан мэдлэг ухаан) хар амь (өөрийн амь, хар амиа бодох зөвхөн өөрийгөө бодох амин хувиа хичээх) хар бие (ганц бие) хар биеэрээ зүтгэх (ганцаар зүтгэх, багаж зэвсэггүй зүтгэх) хар толгой (ганц өөрийн бие) хар толгойдоо гомдох (өөрөө өөртөө гомдох) хар архи (спиртийн хэмжээ нь их архи) хар мах (өөхгүй мах) хар айраг (дан цагаан гүүний сүүг тусгай нарийн аргаар хийсэн архи)

	<p>эсрэг ажиллах тусгай бэлтгэгдсэн цэрэгжсэн бие бүрэлдэхүүн) хар чийг (зөвхөн үдэш шөнийн цагт буух чийг) хар шал (жинхэнэ банзан шалны доорх шургааг шал) хар ямаацах (хүүхэд, ямаа, чоно, эзэн, хүн, хоточ нохой оролцож хүн нохой нь чононоос ямаагаа хамгаалж наадах тоглоом хар нүдэн (нүднийхээ тойронд хартай малын зүсэм, хонины ухархайн хар үс) хар хяруу (хүйтэн дулаан ээлжлэн өөрчлөгдөх нөхцөлд хөрсний гадарга дээр үүсэх нимгэн мөсөн бүрхүүл) хар тамхи (намуу цэцгийн төрөл, урт бөгөөд том навчтай шар буюу улаан цэцэгтэй ургамал) хар борви (тэмээний тойгийн дотор талд их өвчин орж хавдах) хар дэлэн (хонь ямааны сүү гарахгүй болох нэгэн зүйл халдварт өвчин их төлөв дэлэн нь хавдаж сүү нь ширгэнэ) хар цэцэг (цагаан цэцэг өвчин буруугаар эрхэж, хүндэрсэн нь, хонинд тохиолдох нэг зүйл өвчин) хар хүч (байдаг хүч) хар ажил (биеийн хүчний ажил) хар ажилчин (оюуны биш биеийн хүчийг үнэлэн амьдрах хүмүүс) хар алба (төрийн алба, хар алба хүчээр хийх) хар мод (харгай мод гацуур адил болоод яс чийрэг, чанга хүнд дүрс зузаан уул хөвчийн чийглэг чихүүн газар ургадаг нэг зүйл мод шинс хар муйхар бодох төлөвлөх юмгүй арга эвээр биш хүчээр үзэх) хар муйхраар зүтгэх (ухаанаар биш хүчээр хийх гэж зүтгэх) хар хөлс (биеэр дааварлан гарах их хөлс)</p>	<p>хар нутаг (айл нь нүүсэн эзгүй бууц) хар нутагт (хаягдах айлын буурин дээр буцах) хар салхи (ихэнхдээ далай, далайн эрэг орчмын газар үүсдэг маш хүчтэй хуй салхи) хар сээр (хүзүү сээрийн завсар дахь гаднаас түүдийж үзэгдэх нэг нугалам яс) хар чээж (морины бүдүүн хүзүү) хар хамраараа таслуулах (ээлж дугаартай юманд орох гээд орж чадалгүй яг урдуураа таслуулах) хар шүлс (дан шүлс гарах) хар ялаа (дан ганц ялаа олшрох, батгана) хар таамаг (зөвхөн таамгаар үзэх) хар феодал (төрийн түшмэл) хар зах (хотын зах дахь хар бор наймааны газар) хар хүү (идэр залуу) хар намар (намрын гол үе) хараар хүйтрэх (цасгүй хүйтрэх) хар бараан (гаальд цаазлагдсан бараа) хар бяр (эр чадал) хар ташуур (ялтан шийтгэл, гүрмэл сур ташуур) хар тэнхээ (мэхийг үл бодолцох) хар зун (зуны гол үе) хар зуд (цасгүй өвлийн гамшиг) хар алхаа (унааны хөнгөн алхаа) хар аюул (хүнд хүчир аюул зовлон) хар өвөл (хөхөө өвөл цасгүй өвөл) хар бүрий (харуй бүрий) хар хамуу (нойтон хамуу)</p>
<p>II.</p>	<p>хар болох (энгийн иргэн болох) хар иргэн (эгл жирийн ард, сахил санвааргүй хүн) хар тэргүүт (энгийн иргэн, хамаг хүмүүс, хүн төрөлхтөн) хар гэртээ хаан, бор гэртээ богд (гэртээ энгийн чөлөөтэй байх)</p>	<p>хар нүдэн хийх (айрагт архи холих) хэрээ хэрээнийхээ харыг гайхах (адилхан) хар нүд хага татах (нойроос дөнгөж сэрэх) хар нүд хуулах (хар нүд хага татах) хар цагааныг ялгах (зөв буруу, сайн)</p>

		хар аяндаа (өөрийн эрхгүй зөнгөөрөө) хар элэгтэн (харь хүмүүс)	мууг ялгах) хар нүд хамхих (унтах) хар цагаан дуугүй (сайн муу үггүй)
Б.	III.	хар хөө (гай уршиг чирэх юм) хар гэр (шорон) хар ихтэй (маш их хартай, маш их сэрддэг) хар авах (муу санах, сэжиглэх) хар буух (харамсан гэмших, хайран юм гэж сэтгэл гутрах) арван хар нүгэл (биеэр үйлдэх гурав, хэлээр үйлдэх дөрөв, сэтгэлээр үйлдэх дөрөв, арван цагаан буяны эсрэг үйл) хар санаа (муу санаа, сэжигтэй санаа) хар санах (сэжиглэх, итгэхгүй байх, муу санаа агуулах) хар сэр (хардах санаа) хар буруу (муу үл итгэх) хар буруу санах (муу юм бодох, итгэхгүй байх) хар хор (атаархал сэтгэл, бусдын сайнд хорсох, хэтэрхий хартай сэтгэл) хар дарах (аймаар муухай зүүд зүүдлэх) хар толбо (гутамшигт муу нэр)	хар ёртон (бүтэлгүй муу этгээд) хар өвөр (муу өвөр) хар ёр муу (зүйлийн учрал) хар үйл (зүй зарчмаас гаж муу үйлс) хар дарах (муухай зүүд зүүдлэх) хар дотортой (муу санаатай) хар хэл ам (бусдын хэлэх муу үг яриа) хар хэл ам хүрэх (хүний муу хэлснээс ажил үйлс бүтэлгүйдэх) хар хэл амд идүүлэх (хов жив муу ярианы бай болох) хар түвэг (их яршиг) хар хэрүүл (их хэрүүл) хар хоншоор (аманцар зан) хар хор (муу атаа) хар хуян (хар судлын өвчин) хар гөр (гүжир үг) хар мал (эзэнгүй мал) хар сэтгэл (өрөвдөх энэрэхийг мэдэхгүй сэтгэл)
	IV.	хар үсийг нь хагалах (эхнэр болгох) хар нүд хуу татах	хар цагааны газар бичиг хар хүн хар
В.	V.	хар хайрцгийн бодлого (төрийн дотоод нарийн нууц бодлого) хар арилжаа (нууц далдуур хийх хууль бус худалдаа)	хар үг (тагнуул дээрэмчдийн хоорондоо харилцах далд нууц утгатай этгээд хэллэг буюу чимээ дохио) хар хор (далдуур хүнд хор хүргэх үг яриа үйл ажиллагаа)

Хэрэв “бүхэл хэсэг” гэсэн утгын харьцаагаар үзвэл, II, III-рх утга нь дээрх ангиллаас зөвхөн солигдож болно. Учир нь “А”-гийн II, “Б”-гийн III нь “А, Б” хоёрын завсрын шинжтэй болно. “Б”-гийн III нь сэтгэлийн өнгө аяс заасан баймж утгатай юм.

Хэлний нэг агуулгад нэг гаргалга тохирч байвал, түүнийг ганц утга (моносемия), гэх ба нэг гаргалгад өөр өөр утга таарвал түүнийг ижил үг (омонимия) гэнэ. Гэтэл энэ хоёрын дундаж байдлаар нэг гаргалгад олон утга үүсвэл салаа буюу олон утгат нэг үг бүтнэ. Үүнийг “полисемия” гэнэ. Ганц утгыг тохиолдмол утгатай гэх бол тэр үгсийг өөр утгын чадамжтай үгс гэнэ. Тэгвэл, салаа утгыг хувилбар (узема) гэнэ.

Үүнийг И.М.Кобзева дараах байдлаар харьцуулж, ганц утгат үг нь олон утгат, түүнээс ижил үг үүсдэг гэж тэрээр үзжээ. Тухайлбал,

бага нэгж	→	завсрын нэгж	→	их нэгж
ганц утгатай үг	→	салаа утга	→	ижил үг

гэж харьцуулжээ. Ганц утгат үг нь олон утгат, түүнээс ижил үг үүсдэг гэж тэрээр үзжээ.

Монгол хэлний “цул бараан” гэсэн утга “хар” гэсэн тэмдгийн нэр нь ганц утгатай байснаа хэлэхүүний цуваанд олон салаа утгатай болж, “хар хар хийх” гэсэн үгийн дуу чимээний үгтэй гаргалгын хувьд нэг болж, улмаар бие даасан өөр өөр утгат үгийн бүлэглэл үүсгэсэн ижил үг болжээ. Нөгөө талаар, “хар” хэмээх үгийн хар авах, хар дарах, хар буух, хар санах гэсэн үгс нь сэтгэл санааны тавгүй байдлыг заасан үгс бие даасан үг болон хувирсан тул ижил үг гэж үзсэн байна. Эдгээр үгс нь “хар санаа авах, хар юм дарах, хар бодол дарах” гэсэн холбоо үгсийн тодотгуулагч жинхэнэ нэр нь гээгджээ. Утгын хувьд эдгээрийн “хар” гэгч тэмдгийн нэр нь “харанхуй, муухай” гэсэн утга нь “цул бөөн” гэсэн утгаа хадгалсаар буй тул салаа утга буюу “хар” хэмээх үгийн холдсон хувилбар юм.

Т.А.Бертагаев монгол хэлний үгийн салаа утгыг ойр (диффундированные виды) ба холын (рефракционные виды) салаа утгат гэж ангилаад үүний эхнийхэд хараал, цаг, ган, өдөр, санаа, амь, чих, нүд, утас, кино, концерт, жүжиг, асуулт, зорилт, тайлан, илтгэл, тэг, цалин, хүнсний ногоо, эх үүсвэр, морь тавих” гэх мэт салаа утгыг дараагийн хэсэгт нь утас, утасны хороо, цахилгаан утас, утас явуулах, утас цохих; нүүдлийн кино, шатрын нүүдэл, бэх нүүх, байгууллагын хэлтэс; цаг улирах, анги улирах” гэх мэт утгыг багтаажээ.¹²

Иймээс “хар” (qara) хэмээх тэмдгийн нэрийн I ба II, III ба IV ангилал нь дор дороо ойр буюу нугарсан салаа утгатай бол I ба II нь III ба IV дэх хэсэгтэй хол буюу хугарсан салаа утгатай гэж болно. Харин дээрх 5-р утга өмнөх ойр холын салаа утгаас нэлээд ангид учраас холын салаа утга болох ажээ. Харин энэ сүүлчийн утга нь “qar qar ki-” (хар хар хийх) гэдгийн “хар”-тай ижил үг болох боломжтой ажээ.

Resume

Thus, it can be considered that the first group referring to the meaning of adjective “black” (qara) has contact polysemy to the second group, and the third one to the fourth one whereas the groups first and second have distant polysemy from other two. The meaning of the fifth group is far distant and different from the contact and distant polysemies. And it is possible that this last one is a homonym of the “qar” which is in “qar qar ki-”.

Ном зүй

1. Б.Ринчен, “Монгол бичгийн хэлний зүй”, дөтгөөр дэвтэр, дэд, өгүүлбэр зүй, Уб, 1967
2. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, Уб., 2008
3. Ц.Норжин нар, Монгол хэлний толь, Чуулалт хаалга, 1999
4. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Уб.1966, 2013
5. Т.А.Бертагаев. Лексика современных монгольских литературных языков.М., 1974
6. Бурятско-русский словарь, Составил К.М.Черемисов. М., 1973
7. Калмыцко-русский словарь. Под редакцией Б.Д.Муниева, М., 1977
8. О.Ковалевский, Монголо-Французский словарь, Т II, Казань, 1849
9. F.de.Lessing Mongolian-English dictionary. Bloomington,1982
10. G.J.Ramstedt. Kalmükisches Wörterbuch, Helsinki, 1935

¹² Т.А.Бертагаев. Лексика современных монгольских литературных языков. М., 1974, стр.72-123